



ДУАГ
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР АШИГ, ҮР ДҮН

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын код: ДУАГ-САБ/2017/01-ГА

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Агуулга

1. Аудитын нэр
2. Аудитын код
3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх
4. Аудитын зорилт
5. Аудитын хамрах хүрээ
6. Үндсэн мэдээлэл
7. Эрсдэлийн үнэлгээ
8. Аудитын арга зүй
9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд
10. Аудитын хугацаа
11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн
12. Аудитын тайлангийн бүтэц
13. Аудитын үр өгөөж
14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

Хавсралт № 1 Асуудлын шинжилгээ

Хавсралт № 2 Аудитын арга зүй

Хавсралт № 3 Аудитын хөтөлбөр

БАТЛАВ:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ОЮУНЧИМЭГ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.Аудитын нэр: Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн

2.Аудитын код: ДУАГ-САБ/2017-01-ГА

3.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд асуудлыг авч үзнэ.
Үүнд:

- Сангийн эх үүсвэрийг журмын дагуу бүрдүүлж, үнэн зөв тайлагнасан уу?
- Сангийн хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна уу?
- Хяналт үр дүнтэй байна уу?

Дэвшүүлсэн зорилт, дэд зорилтын хүрээнд авч үзэх асуудлын шинжилгээ, гүйцэтгэх горимын нэгтгэлийг Хавсралт 1-д харууллаа.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Сайнцагаан, Эрдэнэдалай, Адаацаг, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт зэрэг нийт сумдын 50 хувийг хамруулан, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны дүрэм, журам, гаргасан шийдвэр, жижиг дунд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх төсөл, гэрээ, түүнийг дүгнэн шалгаруулсан тухай баримт материал, хурлын тэмдэглэл, зээлийн эргэн төлөлтийн тооцоо, сангуудын санхүүгийн тайлан, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэнэ.

6. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж дүгнэлээ.

7.Аудитын арга зүй:

Аудитад Аудитын Олон Улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг мөрдөж, орон тооны бус зөвлөлийн гишүүд, Засаг дарга, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэгч нар болон бусад холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, нөхцөл байдлын шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, асуудлын шинжилгээ, үдшийн цайллагын арга зэрэг аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөрийн дагуу зохих горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитын эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-ээр, Асуудлын шинжилгээг хавсралт №2-ээр, Аудитын арга зүйг хавсралт №3-оор, Аудитын хөтөлбөрийг хавсралт №4 –аар тус тус харуулав.

8. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Хөдөлмөрийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/28 дугаар тушаал,
- Холбогдох бусад, хууль журам

9.Үндсэн мэдээлэл:

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг 2016 оны 3 дугаар сарыг хүртэл баримталж байсан.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2016 онд 134 иргэн, ААНБ-д 877.0 сая төгрөгийн, 2017 оны 1 дүгээр улиралд 43 иргэн, ААНБ-д 313.5 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. 2016 онд 1,147.8 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн ба эргэн төлөлт болон нэмж

олгосон зээлийг судлаж үзэхэд дараахь сумд зээлийг хангалтгүй олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэр	2016 он		
		эргэн төлөлт	олгосон зээл	Зөрүү
1	Говь-Угтаал	43.6	0.8	42.8
2	Баянжаргалан	41.2	5.8	35.4
3	Өлзийт	61.5	1.4	60.2
4	Дэлгэрхангай	35.8	0.8	35.0
	Дүн	182.1	8.7	173.4

Дээрх сумд зээлийн эргэн төлөлтөөс 182.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн боловч шинээр 8.7 сая төгрөгийн зээл олголтыг хийсэн байна.

СХС-ийн авлага нь 2016 оны эхэнд 3,241.7 сая төгрөг, жилийн эцэст 3,083.3 сая төгрөг буюу өмнөх оноос 158.4 сая төгрөгөөр буурсан байна. Дээрх авлага нь ТЕЗ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 50.4 хувийг эзэлж байна.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Сайнцагаан, Говь-Угтаал, Баянжаргалан, Цагаандэлгэр, Өлзийт сумдаас бусад суманд 1,416.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй санхүүгийн тайланд тусгасан зөрчил илэрсэн байна.

10.Аудитын хугацаа

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 07-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 6 дугаар сарын 21-ний өдрийн хооронд, тайлагналын үе шатны ажлыг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 7 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэнэ.

11.Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал чанарын хяналтыг хэрэгжүүлэн, санхүүгийн тайлангийн аудитын багийн ахлах аудитор Б.Гантуяа, шинжээч Ж.Угтахбаяр, С.Жалбаа нар гүйцэтгэнэ.

12. Аудитын тайлангийн бүтэц

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитаас бий болсон үр өгөөж, аудитын зөвлөмж, хавсралт зэргээс бүрдэнэ.

Аудитын үр дүн, аудитын тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулна.

13. Аудитын үр өгөөж

Гүйцэтгэлийн аудитын үр өгөөжийг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2007 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын үр өгөөжийг төлөвлөх, бүртгэх, тайлагнах, хянах, мэдээлэх журам”-ын хавсралт маягт 1,2,3,4,5-аар бүртгэнэ.

14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

А. Боловсон хүчин:

- Боловсон хүчнээс Аудитын менежер болон Санхүүгийн тайлангийн аудитын багаас 3 хүн, нийт 4 хүн – 35 өдөр, нийт 140 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц: бүгд 5,771.8 мянган төгрөг

- Цалин хөлс 4,824.6 мянган төгрөг
- Албан томилолтын зардал: 648.0 мянган төгрөг /Аудитаар 6 суманд 4 хүн 9 хоног ажиллахаар нийт томилолтын зардлыг тооцсон,
- гадаад томилолт: байхгүй
- тээврийн зардал: 299.2 мянган төгрөг

В.Техник хэрэгсэл: Компьютер, принтер, диктафон, зөөврийн компьютер, видео камер, гэрэл зургийн аппарат хувилагч болон бусад техник хэрэгсэл

Г. Бусад: мэдээллийн сан

Аудитын төлөвлөгөөг боловсруулсан:

Ахлах аудитор	Б.Гантуяа
Аудитор	Т.Оюун-Эрдэнэ
Шинжээч	Ж.Угтахбаяр
Шинжээч	С.Жалбаа

2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Хянасан:

Аудитын менежер	Х.Наранцацрал
-----------------	---------------

2017 оны.....дугаар сарын-ны өдөр

Аудитын ерөнхий эрсдэлүүд ба үнэлгээ

Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үнэлгээ		
	магадлал	үр дагавар	үнэлгээ
Байгууллагын эрсдэл			
Сан нь Төрийн сангаас гадуур данстай байх	Бага	Бага	Бага
Сангийн орлого, зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгагдаагүй байх.	Бага	Бага	Бага
Эргэн төлөгдсөн зээл, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлээгүй байх	Дунд	Их	Дунд
Зээлдэгч зээлийг хугацаанд нь төлөөгүй, зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан болон зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд алданги тооцож аваагүй байх.	дунд	Их	Дунд
Төсөл сонгон шалгаруулахад сумын иргэдийн саналыг аваагүй, түүнийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлээгүй байх.	Дунд	Их	Дунд
Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байх.	Бага	Бага	Бага
Сангийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаагүй байх.	Дунд	Их	Дунд
Төсөл нь шалгарсан иргэн, аж ахуй нэгж байгууллагатай зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах, гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавих эрх бүхий албан тушаалтан зохих ёсоор хэрэгжүүлээгүй байх.	Дунд	Их	Дунд
Зээлийн хүүгийн орлого, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажилагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, сумын жил бүрийн төсөвтэй хамт батлуулаагүй байх.	Дунд	Их	Дунд
Тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй, оновчтой бус байх.	Их	Их	Их
Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлж, эрсдэлийг даван	Их	Их	Их

туулах талаар тусгаагүй байх.			
Төсөл шалгаруулах ажлын хэсгийг ИТХ-аас журмын дагуу байгуулаагүй байх	бага	дунд	бага
Сангаас зээл олгохдоо төслийг журмын дагуу шалгаруулаагүй байх	бага	дунд	бага
Журмын дагуу шалгуур хангасан хүмүүст зээл олгоогүй байх	бага	бага	бага
Бичиг баримтыг журмын дагуу бүрдүүлээгүй байх /төсөл, эрсдэлийн тооцоо, гэрээ, Засаг даргын захирамж гэх мэт/	бага	дунд	бага
Үйл ажиллагааны эрсдэл			
Зээл олгосноор үйлдвэрлэл үйлчилгээ нэмэгдээгүй, ажлын байр бий болоогүй байх	бага	их	дунд
Ажлын хэсэг журмын дагуу сангийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй байх	дунд	их	дунд
Сангийн үйл ажиллагааг ИТХ-д тайлагнаж, мэдээлээгүй байх	бага	их	дунд
Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, зээлийн эргэн төлөлтийг иргэдэд ил тод мэдээлээгүй байх	Их	Их	Их
Хөндлөнгийн эрсдэл			
Шалгуур хангасан төсөл ирээгүй байх	бага	дунд	бага
Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байх	дунд	их	их
Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй байх	дунд	их	их

Эрсдэлийн үнэлгээ	тоо
Их	5
Дунд	9
Бага	8